



**MBR
AUDIT**

АУДИТ
БАТАЛГААЖУУЛАЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ

Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК
УБ, Баянзүрх дүүрэг, 6-р хороо
Барилга МН ХХК-ийн оффис 303
Утас: 976-7000-5329
Гар утас: 976-9985-1823
И-мэйл: mbr.audit.lic@gmail.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“АНД ЭНЕРГИ”-ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД:

Санхүүгийн Тайлангийн Аудитын Тайлан

Дүгнэлт

Бид **Анд Энерги ХК** (цаашид компани гэх)-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн орлогын тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Компанийн санхүүгийн тайлан нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх), түүнд нийцүүлэн Сангийн сайдын тушаалаар баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (НБЕЗОУСЗ)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус компаниас хараат бус байж, НБЕЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт, нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохистой үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд Хүлээх Үүрэг Хариуцлага

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь Компанийн удирдлагын үүрэг хариуцлага юм. Залилан эсвэл алдааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбоотой удирдлагын шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтууд нь мөн энэхүү хариуцлагад хамаарна.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Компанийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайланд тодруулж, компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан санхүүгийн тайланг бэлтгэх болон санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.





**MBR
AUDIT**

АУДИТ
БАТАЛГААЖУУЛАЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ

Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК
УБ, Баянзүрх дүүрэг, 6-р хороо
Барилга МН ХХК-ийн оффис 303
Утас 976 7000 5329
Гар утас 976-9985-1823
И-мэйл mbr.audit.lc@gmail.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн Тайлагналын Аудитад Аудиторын Хүлээх Үүрэг Хариуцлага

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх нотолгоо олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох ба дангаараа эсвэл нэгдсэн дүнгээрээ уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудитыг гүйцэтгэхдээ мэргэжлийн үнэлэмж, үнэлгээ хийх мөн мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул эдгээрээс үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлээгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан нотолгоондоо үндэслэн компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь компанийн тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог





**MBR
AUDIT**

АУДИТ
БАТАЛГААЖУУЛАЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ

Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК
УБ, Баянзүрх дүүрэг, 6-р хороо
Барилга МН ХХК ийн оффис 303
Утас 976 7000 5329
Гар утас 976-9985-1823
И-мэйл: mbr.audit.llc@gmail.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)


Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд багтсан хэдий ч санхүүгийн тайлан ба аудиторын тайланд багтаагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад илрүүлсэн томоохон асуудлууд, тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Өмнөх жилийн аудитор

Компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн аудитыг Мүүрь Аудит ХХК гүйцэтгэж, 2020 оны 03 дүгээр сарын 30-ны өдөр аудиторын зөрчилгүй дүгнэлт гаргасан байна. 2019 оны 12 дугаар 31-ны өдрөөрх санхүүгийн тайлангийн зэрэгцүүлэх мэдээлэл нь уг зөрчилгүй дүгнэлт бүхий санхүүгийн тайланд үндэслэсэн.



Д.Түмэнжаргал Ерөнхий захирал,
Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс,
2021 оны 3 дугаар сарын 01-ний өдөр

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөр хүчин тогтодог үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа санхүүгийн тайлангийн үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь уг санхүүгийн тайлангийн үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу. Энэхүү тайлан зөвхөн тус Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан болно. Бид энэхүү санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравлагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

“АНД ЭНЕРГИ” ХК
2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодруулга	АУДИТЛАГДСАН	АУДИТЛАГДСАН
		2020.12.31 (мян.төг)	2019.12.31 (мян.төг)
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3	25,659	46,523
Дансны авлага	4	197,477	219,822
Татвар, НДШ-ийн авлага		11,962	-
Бусад авлага	4	32,656	73,790
Бараа материал	4	619,299	343,075
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6	-	74,738
Эргэлтийн хөрөнгийн дүн		887,053	757,948
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	7	1,769,503	1,656,038
Биет бус хөрөнгө	8	62,988	5,415
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		1,832,491	1,661,453
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		2,719,544	2,419,401
Өр төлбөр ба эздийн өмч			
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	9	17,431	7,573
Бусад өглөг	9	122	12,695
Татвар, НДШ-ын өглөг	9	19,641	22,662
НӨАТ-ын өглөг	9	46,085	43,000
Зээлийн хүүгийн өглөг	9	-	5,437
Богино хугацаат зээл	9	489,425	293,068
Урьдчилж орсон орлого	10	6,985	1,643
Богино хугацаат өр төлбөрийн дүн		579,689	386,178
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	11	47,450	47,450
Урт хугацаат өр төлбөрийн дүн		47,450	47,450
Өр төлбөрийн нийт дүн		627,139	433,628
Эздийн өмч			
Өмч			
-Хувьцаат капитал	10	78,071	78,071
Нэмж төлөгдсөн капитал		1,470,541	1,470,541
Дахин үнэлгээний нэмэгдэл		264,224	72,574
Хуримтлагдсан ашиг	10	279,569	364,587
Эздийн өмчийн дүн		2,092,405	1,985,773
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		2,719,544	2,419,401

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.



MBR-AUDIT

“АНД ЭНЕРГИ” ХК

2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

	Тодруулга	АУДИТЛАГДСАН 2020.12.31 (мян.төг)	АУДИТЛАГДСАН 2019.12.31 (мян.төг)
Борлуулалтын орлого (цэвэр)	11	2,205,821	1,380,290
Борлуулалтын өртөг	11	(1,312,416)	(880,253)
Нийт ашиг (алдагдал)	11	893.404	500,037
Үйл ажиллагааны зардал	13.1	(738,292)	(377,611)
Санхүүгийн зардал	13.2	(99,062)	(43,862)
Бусад зардал	13.3	(31,697)	(51,495)
Бусад орлого		700	7,861
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	13.4	4.0	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		25,058	34,929
Орлогын татварын зардал	14	502	(11,946)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		24,555	22,983
Дахин үнэлгээний нэмэгдэл хэрэгжсэн дүн		-	(803)
Бусад олз гарз		-	-
Нийт дэлгэрэнгүй ашиг(алдагдал)		24,555	22,180
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	31.5		29

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.



“АНД ЭНЕРГИ” ХК
2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт (мянган төгрөгөөр)	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлаг дсан ашиг	Нийт дүн
2019-01-01-ний үлдэгдэл	78,071	1,4710,541	73,377	296,478	1,918,467
НББ-ийн өөрчлөлт, алдааны залруулга	-	-	-	45,126	45,126
Залруулсан үлдэгдэл	78,071	1,4710,541	73,377	341,604	1,963,593
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	22,983	22,983
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	(803)	-	(803)
2019-12-31-ний үлдэгдэл	78,071	1,4710,541	72,574	364,587	1,985,773
Залруулсан үлдэгдэл	78,071	1,4710,541	72,574	364,587	1,985,773
НББ-ийн өөрчлөлт, алдааны залруулга	-	-	-	(15,888)	(15,888)
Залруулсан үлдэгдэл	78,071	1,4710,541	72,574	348,699	1,969,884
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	24,555	24,555
Зарласан ногдол ашиг	-	-	-	(93,685)	(93,685)
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	191,650	-	191,650
2020-12- 31-ний үлдэгдэл	78,071	1,4710,541	264,224	279,569	2,092,405

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.



MBR-AUDIT

“АНД ЭНЕРГИ” ХК
2020 он 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	АУДИТЛАГДСАН 2020.12.31 (мян.төг)	АУДИТЛАГДСАН 2019.12.31 (мян.төг)
1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	2,469,821	832,096
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,113,943	797,853
Бусад мөнгөн орлого	355,878	34,243
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	2,432,451	898,017
Ажиллагчдад төлсөн	333,807	158,057
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	58,726	49,326
Бараа материал худалдан авахад төлсөн	1,557,530	440,207
Ашиглалтын зардалд төлсөн	6,387	8,280
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,226	11,231
Хүүний төлбөрт төлсөн	99,373	24,450
Татварын байгууллагад төлсөн	192,881	98,071
Даатгалын төлбөрт төлсөн	-	610
Бусад мөнгөн зарлага	181,522	107,785
Үндсэн үйл аж-ны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	37,369	(65.921)
2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	311	29,087
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл мөнгөн урь-ны буцаан төлөлт	-	29,087
Хүлээн авсан хүүгийн орлого	311	-
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	91,326	145,509
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	59,008	111,109
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	32,318	34,400
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(91,015)	(116.422)
3. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖ-НЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	555,477	417,650
Зээл авсан, өрийн үнэт цаас гар-аас хүлээн авсан	555,477	417,650
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	523,095	205,929
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	438,778	205,929
Төлсөн ногдол ашиг	84,317	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	32,382	211,721
Валютын ханшийн зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(20,864)	29,377
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	46,523	17,145
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	25,659	46,523



Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

